



МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖИЙН ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРЛЫН ТУШААЛ

2015 оны 08 сарын 25 өдөр

Дугаар 246


Улаанбаатар хот

Арилжаанд оролцох эрхийг
сэргээх тухай

Монгол Улсын Компанийн тухай хуулийн 83 дугаар зүйлийн 83.1, "Монголын хөрөнгийн бирж" төрийн өмчит хувьцаат компанийн Дүрмийн 8 дугаар зүйлийн 8.1, 8.10.11, Гүйцэтгэх захирлын 2015 оны 8 дугаар сарын 10-ны өдрийн 230 дугаар тушаалыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. "Санар ҮЦК" ХХК-ийн арилжаанд оролцох эрхийг 2015 оны 8 дугаар сарын 25-ны өдрөөс эхлэн сэргээсүгэй.
2. Цаашид хууль тогтоомж, журам заавар болон "Монголын хөрөнгийн бирж" төрийн өмчит хувьцаат компанитай байгуулсан "Хамтран ажиллах гэрээ"-ээр хүлээсэн үүргээ тогтмол биелүүлэн ажиллахыг "Санар ҮЦК" ХХК /М.Бүрэнбаяр/-д анхааруулсугай.

ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРЛЫН
ҮҮРЭГ ГҮЙЦЭТГЭГЧ



Д. АНГАР